

## Дээлтэй, сүүтэй хэдий ч мэтгэлцээнгүй сонгууль

Монголчууд ардчилалд шилжсэнээс хойшхи зургаа дахь удаагаа төрийн тэргүүнээ сонголоо. Энэ удаагийн ерөнхийлөгчийн сонгууль урьд өмнөх сонгуулиудтай харьцуулахад ихээхэн онцлогтой болж өнгөрөв. Анх удаагаа эмэгтэй нэр дэвшигч тодрон гарлаа. Мөн 80 жил эрх барьсан нам маань хоёр хуваагдаж, нэг угшилтай хоёр нэр дэвшигч өөр хоорондоо үзэлцэв. Сонгуулийн сурталчилгаа хэрхэн явагдсаныг эргэн нэг харцгаая.

### Цэвэр гарны домог

МАН-аас нэр дэвшигч Б.Бат-Эрдэнийн сурталчилгааны гол мессеж болон уриа нь сонгуулийн сурталчилгааны эхний долоо хоногт бусад хоёр нэр дэвшигчийнхийг бодоход илүүтэй танил болсон. Түүний “Миний нэр цэвэр, миний гар цэвэр, миний сэтгэл цэвэр” хэмээх мессеж нь хүмүүсийн эгдүү болон инээдийг хүргэсэн хэдий ч яах аргагүй хамгийн их анхаарал татсан мессеж болсон билээ. Бөх хүн нэр дэвшлээ, юу ярьж, яах бол гэсэн сонгогчдын хүлээлтэд Б.Бат-Эрдэнийн энэхүү цэвэр гарны тухай мессеж хариулт болж очсон юм.



Харин түүний “Эвийг эрхэмлэж, зөвийг дэмжинэ” хэмээх уриа нь МАН-ын улиг болсон эв нэгдэл, эвтэй байхдаа хүчтэй гэх мэт хуучны лоозонгуудыг санагдуулж байсан юм.

Нөгөө хоёр өрсөлдөгч болох Ц.Элбэгдорж болон Н.Удвал хоёрын хувьд сонгуулийн уриа нь төдийлөн хүмүүст хүрсэнгүй. Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж уг нь “Монгол улсын төлөө зүтгэе” гэсэн уриатай өрсөлдсөн боловч сурталчилгааны зурагт самбарууд дээрх “Ерөнхийлөгчөө дэмжье” гэсэн мессеж илүү танил болсон билээ.



## Мартахын аргагүй нэр дэвшигч

МАХН-аас нэр дэвшсэн, Монголын хүн амын тэн хагасын төлөөлөл болсон анхны эмэгтэй нэр дэвшигч Н.Удвалын сурталчилгаа хангалттай сайхан болж чадсангүй. Түүний “Таван асуудал, таван зорилт” хэмээх сонгуулийн уриа нь ойлгомжгүйгээс гадна уриа гэхээс илүү мөрийн хөтөлбөрийн гарчиг шиг харагдаж байв. Уг нь сонгуулийн уриа бол тухайн нам юмуу нэр дэвшигчээ хамгийн цөөн үгээр хамгийн ойлгомжтойгоор илэрхийлж хүмүүсийн анхаарлыг татсан байх ёстой юм. Түүний зурагт самбарууд дээр энэхүү уриа нь бус “Шударга байхдаа хүчтэй Шударга бусыг өөрчилцгөө” гэсэн ойлгоход хэцүүхэн мессеж тавигдаж байлаа.



Н.Удвалын телевиз дэх сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгүүдээс үзэхэд ерөнхийдөө сөрөг сурталчилгаа давамгайлсан шинжтэй байсан. Шуудхан хэлэхэд экс ерөнхийлөгч Н.Энхбаярын гомдол, тунирхал энэ намын нэр дэвшигчийн сурталчилгаанаас нэвт ханхалж байлаа. Нэр дэвшигч Н.Удвалын хувийн тоглолт багатай, цаанаас захиалгатай аятай өнөө л МАХН гэсэн нэрийг сольж түүхэн том алдаа гаргасан, Н.Энхбаяр ямар мундаг хүн байлаа, одоо яасныг хар гэх маягийн сурталчилгаа гэхэд хэцүү, дурсамж маягийн юм яваад байсан. Харин Н.Удвалын сурталчилгаа сүүлдээ сонгогчдоор өрөвдүүлэх тактик барьсан нь түүний сонгогчдод илгээсэн ил захидал болон халз ярилцлагын үеэрх ногоон торгон дээлээр гоёдог ээжийн тухай ярьснаас харагдаж байна. Тэрбээр “Надад бусдын адил өөрийгөө хангалттай сурталчлах хөрөнгө мөнгө, бэл бэнчин, бусдыг өөрийн төлөө ажиллуулах эрх мэдэл байсангүй. Өрсөлдөгч нар гудамж дүүрэн зурагт самбараа байрлуулж сурталчилгааны хугацаанд түүнийгээ хэд хэдэн удаа сольж байхад би Улаанбаатар хотод өлгөсөн аравхан самбарынхаа мөнгийг ч бүрэн төлж чадалгүй сурталчилгаагаа дуусгаж байгаа” хэмээн захидалдаа бичсэн байв.

Эмэгтэйчүүд нэгэн санаатайгаар дэмжиж, эмэгтэйчүүдийн ТББ-ууд асар том хөдөлгөөн, аян өрнүүлж байж эмэгтэй ерөнхийлөгч сонгогддог практик дэлхийд бий. Харин энэ удаа манай эмэгтэйчүүд болон ТББ-уудын хувьд ингэж чадсангүй, нэр дэвшигч эмэгтэй маань нэлээд ганцаардангуй сурталчилгаа хийсэн дээ. Гэхдээ ямар ч байсан Монголын ерөнхийлөгчийн сонгууль дахь анхны эмэгтэй нэр дэвшигч гэдгээрээ түүхэнд үлдэж, хатуу ширүүн улс төрийн ертөнцөд гэрэл гэгээ оруулсан Н.Удвалын эр зориг мартагдахгүй буй заа.

### Дээлтэй сонгууль хийгээд үндсэрхэг үзэл

Энэ удаагийн сонгуульд манай гурван нэр дэвшигч гурвуулаа л дээл өмсч, “Монгол гэсэн нэрээрээ гоёж” өрсөлдөв. Хөтөлгөө морьтой хүрэн дээлтэй Ц.Элбэгдорж, мөн л хүрэн дээлтэй, гаанс нэрсэн Б.Бат-Эрдэнэ, ногоон дээлт Н.Удвал гээд л.





Монгол дээлээ өмсч зургаа авахуулах сайхан л даа, гэвч дээлний цаанаас зарим нэр дэвшигчийн хэлж байгаа үг яриа нь сонгогчдод төдийлөн таалагдсангүй. МАН жил жилийн сонгуулиар өрсөлдөгчдөө угсаа гарлаар ялгаварласан сөрөг сурталчилгаа явуулдгийг аварга Б.Бат-Эрдэнэ энэ удаа ч мөн тойрч гарсангүй. Тэрбээр сурталчилгааныхаа нээлт дээр “Миний гарал үүсэл төрийн тэргүүний зэрэг дэвд нийцнэ” гэж хэлснээрээ олон хүний дургүйг хүргэсэн. Нэг бүдэрвэл долоо бүдэрнэ гэгчээр үүний дараа МАН-ын албан ёсны сайт болон Үнэн сонины сайтуудаар “Үнэхээр Б.Бат-Эрдэнийг **цэвэр монгол хүн** гэдэгт эргэлзэхийн арга даанч үгүй” гэх мэтээр үндсэрхэг үзэл, хатуухан хэлэхэд фашизм үнэртсэн нийтлэл гаргаж нэр дэвшигчээ “онигоонд” оруулав.

### Сүүтэй ерөнхийлөгч

Энэ удаагийн сонгууль юм юмтай болж өнгөрсний нэг нь сүү барьсан ерөнхийлөгчийн зураг байлаа. Нэр дэвшигч Ц.Элбэгдоржийн сурталчилгааны хамгийн сүүлчийн зураг самбар нь сүүтэй аяга барьсан зураг байлаа. Монголд ирсэн нэгэн гадаад “Энэ нэр дэвшигч аяганд юу хийчихсэн юм бэ” хэмээн асуухад “Монголчууд архи их уудаг болохоор ерөнхийлөгч маань сүү уугаач гэж уриалж байгаа юм” гэж хэлэхэд ихэд гайхаж байна лээ, санаанд нь огт бууж өгөхгүй байгаа бололтой. Харин “Ээжийн чанасан цай, өрөм зөөхий дүүрэн байдаг ээжийн бор аяга” гэх мэтээр дуулдаг монголчуудад бол сүү барьсан ерөнхийлөгч тэгтлээ их хачирхалтай санагдаагүй бололтой.

Ц.Элбэгдорж энэ сонгуульд монгол дээл, хөтөлгөө морь, сүү гэх мэтээр чимэглэж эерэг сурталчилгаа давамгайлсан тактик барилаа. Ямагт элдвийг сэдэж, энд тэндгүй явж, ихийг ярьдаг ерөнхийлөгчөө илүү юм хийж илүү юм ярьчихгүй л бол сонгуульд ялчих байх гэж таамагласан маань алдсангүй. Аварга А.Сүхбат, Асашёорюу Д.Дагвадорж нарыг АН-д элсүүлж арын фоноо чимэглэснийг нь эс тооцвол Элбэгдорж ерөнхийлөгч энэ удаа ноцтой алдаа гаргасангүй сонгуульдав.




## Цахим ертөнц дэх өрсөлдөөн

Энэ удаагийн сонгуулийн нэг онцлог бол интернэт дэх өрсөлдөөн байлаа. Нийгмийн сүлжээ буюу цахим ертөнц дэх facebook, twitter, блог хуудсуудаар сонгуулийн талаар ёстой есөн шидийн сурталчилгаанууд тавигдлаа.

Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулинд зааснаар сурталчилгааны албан ёсны бүхий л үйл ажиллагаа цаг хугацаа, орон зай, агуулгын хувьд ихээхэн хязгаарлагдмал явагдах ёстой болж байгаа тул нэр дэвшигчид болон улс төрийн намууд одоогоор харьцангуй чөлөөтэй, дээрээс нь зардал мөнгө бага шаарддаг цахим сүлжээг ашиглахаас ч өөр аргагүй байлаа. Нэр дэвшигчдийн багийнхан энэхүү сул орон зайд сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхлэхээс өмнө хэдийнэ эерэг сөрөг сурталчилгаа явуулаад эхэлчихсэн билээ. Хэдийгээр гурван нэр дэвшигч байсан ч гол өрсөлдөөн МАН ба АН-ын нэр дэвшигчдийн хооронд явагдаж цахим ертөнцөд ч Б.Бат-Эрдэнэ, Ц.Элбэгдорж нарын янз бүрийн хошин гэмээр мессеж мэдээллүүд ар араасаа хөврөв.

Facebook-ээр Б.Бат-Эрдэнэ бол сайхан биерхүү монгол эр, харин Ц.Элбэгдорж бол морин дээр суухад хөл хүрэхгүй бие жижиг гэх маягийн зурагнууд тараагдаж Б.Бат-Эрдэнэ аваргын сайхан дэвсэн, барилдсан зураг дүүрсэн билээ. Харин үүний хариуд Ц.Элбэгдоржийн багийнхан “Элбэгдоржийг хувьсгалын ажил хийж явахад Бат-Эрдэнэ юу хийж байв?” хэмээх сөрөг сурталчилгааг цахим орон зайд оруулж ана мана үзэлцэв.



**Like**

**Share**



	<p><b>1990 онд</b>          Ардчилсан хувьсгал өрнөөд          Элбэгдорж жагсаж явахад          Бат-Эрдэнэ аварга юу хийж байв?          Мөнх-Эрдэнэ арсланг нухаж байв</p>	
	<p><b>1992 онд</b>          Элбэгдорж УИХ-д сонгогдож байхад          Бат-Эрдэнэ аварга юу хийж байв?          Мөнх-Эрдэнэ арсланг нухаж байсан</p>	
	<p><b>1996 онд</b>          Элбэгдорж          УИХ-ын дэд дарга байх үед          Бат-Эрдэнэ аварга юу хийж байв?          Мөнх-Эрдэнэ арсланг          5 цаг нухаж байлаа</p>	
	<p><b>1998 онд</b>          Элбэгдорж МУ-ын ерөнхий сайдаар          ажиллаж байхад          Бат-Эрдэнэ аварга юу хийж байв?          Мөнх-Эрдэнэ арсланг нухаж л байсан</p>	
	<p><b>2002 онд</b>          Элбэгдорж          Харвард төгсөөд ирэхэд          Бат-Эрдэнэ аварга юу хийж байв?          Мөнх-Эрдэнэ арслангаа          нухсаар л байсан....</p>	

## Мэтгэлцээнгүй мэтгэлцэв

Сонгуулийн сурталчилгааны сүүлчийн том үйл явдал болох нэр дэвшигчдийн халз мэтгэлцээн энэ удаа аанай л асуултад ээлжлэн хариулсан уйтгартайгаар явагдав. Уг нь бол сонгогчдын хамгийн их хүсэн хүлээж байсан зүйл бол халз мэтгэлцээн байлаа. МҮОНТ-ийн бэлдэж найруулсан энэхүү халз ярилцлага нь хөтлөгчдөөсөө авахуулаад зохион байгуулалт, агуулгын хувьд олны шүүмж дагууллаа. Улиг болсон ерөнхий асуултад нэр дэвшигчид ээлжлэн хариулж, өрсөлдөгчөө шүүмжлэн няцаах, өөрийн байр суурийг илэрхийлэх ямар ч боломж гарсангүй. Зөвхөн энэ халз ярилцлагыг хараад л МҮОНТ хэрхэн хоцрогдож байгааг мэдэх боломжтой байлаа. Бид Өрнөдийн ардчиллыг нэгэнт авсан юм чинь улс төрийн соёлд нь мөн суралцмаар байх юм. Тэнд нэр дэвшигчид ухаанаа уралдуулан мэтгэлцдэг бол Монголд сугалаа сугалж асуултад хариулаад л өнгөрч байгаа нь үнэхээр эмгэнэлтэй. Цаашид мэтгэлцээний комисс юмуу хороо гээчийг нам, нэр дэвшигчид хамтран бүрдүүлж дүрэм журмаа тогтоож дэлхийн жишгээр мэтгэлцдэг болох юмсан.